



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 04 сарын 18 өдөр

Дугаар А/41

Улаанбаатар хот

Нийслэлийн “Улаанбаатар сурагчдын
лиг-2025” волейболын тэмцээнд баг тамирчдыг
оролцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсэг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийслэлийн “Улаанбаатар сурагчдын лиг-2025” өсвөрийн шигшээ тэмцээн 2025 оны 04 дүгээр сарын 21, 22-ны өдрүүдэд Буянт-Ухаа спорт цогцолборт зохион байгуулагдах тул 2 насны ангилалд баг тамирчдыг бэлтгэн оролцуулахыг Биеийн тамир, спортын хороо (Г.Тэмүүлэн)-нд үүрэг болгосугай.

2.Тэмцээнд оролцоход шаардлагатай 1,546,000 (Нэг сая таван зуун дөчин зургаан мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг Нийгмийн хөгжлийн хэлтэс (Б.Цогжавхлан)-т, санхүүгийн тайланг 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Засаг даргын Тамгын газарт ирүүлэхийг Биеийн тамир, спортын хороо (Г.Тэмүүлэн)-нд тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

AJIL\2025 он ажил\захирамж

1225010215

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны... дугаар сарын... ны өдрийн
... дугаар захирамжийн хавсралт



УЛААНБААТАР СУРАГЧДЫН ЛИГ “ВОЛЕЙБОЛ”-ЫН
ТЭМЦЭЭНД ЗАРЦУУЛАГДАХ ТӨСӨВ

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг Бүрийн үнэ	Нийт үнэ	Тайлбар
1	Хоол	ш	68	20,000	1,360,000	Эрэгтэй баг 16, эмэгтэй 16 нийт 32 хүүхэд, 2 дасгалжуулагчийн 2 өдрийн хоол
2	Ус	ш	80	1,200	96,000	-
3	Ундаа	ш	50	1,800	90,000	-
Нийт					1,546,000	-